

ДӨРВӨЛЖИН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИД АЖЛЫН АЛБАНЫ 2019 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ /ямар бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ/	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээг хэмжих шалгуур үзүүлэлт /тоо, хувь, чанар.../	Тухайн жилийн хүрэх түвшин	Төсөв, эх үүсвэр (мян.төг.)	Хүрсэн түвшин хэрэгжилт	Хугацаа /сар, улирал/	
1	2	3	4	5	6	7	8
Зорилт-1. Орон нутгийн хөгжлийн бодлогыг оновчтой тодорхойлж, сумынхаа эдийн засаг,нийгмийн асуудлыг бие даан шийдвэрлэнэ							
1.1.1	Сумын ИТХ-ын ээлжит хуралдааныг 2-оос доошгүй удаа зохион байгуулан, шаардлагатай тохиолдолд тулгамдаж буй асуудлаар ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулна../ИТХ-ын 2016-2020 онд баримтлах бодлогын 1.2-т/	2-оос доошгүй хуралдаан	2-оос доошгүй удаа хуралдсан байна		ИТХ-ын долоодугаар хуралдааныг 2019 оны 06 сарын 02 ны Тэргүүлэгчдийн хурлаар товыг зарлан, хэлэлцэх асуудлыг баталж, бэлтгэл ажлыг хангаж, 2019 оны 06 дүгээр сарын 14 ны өдөр хуралдсан. Сумын ИТХ-ын наймдугаар хуралдааныг 2019 оны 12 дугаар сарын 19 ний өдөр хуралдуулахаар Тэргүүлэгчдийн 2019 оны 17 дугаар тогтоолоор шийдвэрлэж, бэлтгэл хангагдсан.	6,12	100%
1.2.1	Сумын ИТХ-ын Тэргүүлэгчид, ажлын албаны 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулна. /ИТХ-ын 2016-2020 онд баримтлах бодлогын 3.1-т/	Баталж тогтоол гарна	Төлөвлөлтийг оновчтой хийсэн байна		Сумын ИТХ, түүний Тэргүүлэгчдийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг Иргэд, Төлөөлөгчид, Тэргүүлэгчдийн саналыг тусган боловсруулж, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан.	2 сард	100%

1.2.2	Төлөөлөгчдийн хуралдаанаар хэлэлцэх асуудлуудыг урьдчилан Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэж, зөвлөмж чиглэл өгөх /сумын ИТХ-ын 2016-2020 онд баримтлах бодлогын 3.4 дэх заалт/	2 оос доошгүй удаа хэлэлцэнэ	Биелэлтийн хувийг 50 иас дээш гаргах		ИТХ-ын хуралдаанаар хэлэлцэх асуудлуудыг урьдчилан 2019 оны 06 дугаар сарын 12 ны өдрийн Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэв.	6.11 сард	70%
1.2.3	Хурлын шийдвэрээр томилсон зөвлөл, комиссын тайлан, мэдээллийг сонсож дүгнэлт өгнө /сумын ИТХ-ын 2016-2020 онд баримтлах бодлогын 3.2-т/	Хуралд 1 удаа тайлан тавьж, 2 удаа биелэлт ирүүлнэ	Биелэлтийн хувь 70		Сум хөгжүүлэх сангийн тайлан, Сумын амьжиргаа дэмжих зөвлөлийн тайлан, Улаан загалмайн анхан шатны хорооны тайланг хэлэлцсэн.	Улирал тутам	70%
1.2.4	ИТХ, Тэргүүлэгчдээс гаргасан шийдвэрийн хэрэгжилтийн явцыг хэлэлцэн, үр дүнг тооцож ажиллана./ сумын ИТХ-ын 2016-2020 онд баримтлах бодлогын 3.2т/	2 удаа хэлэлцэнэ	Биелэлт 90 хувьд		Шийдвэрийн хэрэгжилтийн явцыг 6.12 дугаар сард холбогдох албан тушаалтанаас авч Тэргүүлэгчдээр үр дүнг тооцон ажиллав. ИТХ-ын тогтоолын биелэлт 90 хувьтай байна.	6,12 сард	100%
1.2.5	Бодлогын хороодын ажлалх ажлын график гарган батлуулна/ сумын ИТХ-ын 2016-2020 онд баримтлах бодлогын 3.2-т/	Хяналт шалгалт хийсэн тоо	Графикийн хэрэгжилт		Нийгмийн бодлогын хороо, байгаль орчин экологийн бодлогын хороод ажлын төлөвлөгөө батлан мөрдөж, хэрэгжилт 90 хувьтай байна.	1-р улиралд	70%
1.2.6	Хайгуулын болон ашиглалтын компаниудын үйл ажиллагаанд хяналт хийсэн ажлын тайланг хэлэлцэх /сумын ИТХ-ын 2016-2020 онд баримтлах бодлогын 1.24, 3.6 –д/	Тус бүрийн тайланг хэлэлцэнэ	Зөвлөмж гаргах		Ашиглалтын болон хайгуулын зөвшөөрөлтэй 16 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтын мэдээлэлийг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдэд ирүүлсэн,	1-р улиралд	70%
1.2.7	Байгууллагуудад ашиглалтын хугацаа дууссан цаашид ашиглах боломжгүй болсон хөрөнгийг Тэргүүлэгчдийн хурлаар	2 удаа	Шийдвэр гарган биелэлт 90 ээс дээш хувь		ИТХ-аас төсвийн байгууллагуудын хөрөнгөтэй танилцаж, орон нутгийн өмчийн талаар 4 байгууллагын санал хүсэлтийг хүлээн авч хуулийн хүрээнд хянан шийдвэрлэж, цэцэрлэгийн 3 сая	Тухай бүр	

	хэлэлцүүлэн шийдвэрлэнэ /МУЗЗНДНТУТХ-ийн 18,1,3-м/				209 000 төгрөгийн хөрөнгийг данснаас хасах зөвшөөрөлийг Аймгийн ИТХ-аас гаргав.		100%
1.2.8	Сумын Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг тооцож үнэлэлт, дүгнэлт өгнө /сумын ИТХ-ын 2016-2020 онд баримтлах бодлогын 3.4-м/	1 удаа хэлэлцэнэ	Биелэлт 70 хувьд хүргэх		Сумын Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийн явцыг 2019 оны 6 дугаар сарын 14 ний ИТХ-ын хуралдаанаар хэлэлцэн зөвлөмж чиглэл өгсөн, 8 дугаар хуралдаанаар хэлэлцэнэ	12 сард	100 %
1.2.9	“ИТХ-аас сумын Засаг дарга, Засаг даргын тамгын газар, бусад байгууллага иргэдтэй харилцах, хамтран ажиллах журам”-ын хэрэгжилтийг сонсож дүгнэлт өгнө/ сумын ИТХ-ын баримтлах бодлогын 3.2-м/	1 удаа	Журмын хэрэгжилт тооцож, шуурхай зөвлөгөөн дээр танилцуулна		ИТХ, Засаг даргаас харилцан хамтран ажиллах журмыг 2016 онд баталсан одоогоор мөрдөн ажиллаж байна.	4 улиралд	70%
1.2.10	“Ахмадаасаа суралцъя” үйл ажиллагааг зохион явуулахад оролцоно /сумын ИТХ-ын 2016-2020 онд баримтлах бодлогын 1.5-д/	1 удаа	Байгууллага бүр оролцож, дүгнэлт гаргах		Ахмадын сургааль алт дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг ЗГ-ын 2017 оны 89 дүгээр тогтоолоор дүгнэхэд 100 хувьтай, ахмадаасаа суралцъя арга хэмжээнд ИТХ-ын мэндчилгээг дэвшүүлэн зохион байгуулалтанд орж ажилласан.	3-р улиралд	100%
1.2.11	Сум хөгжүүлэх сангийн зээл олголт, эргэн төлөлт, хэрэгжилтийн явц үр дүнг тооцон үнэлэлт дүгнэлт өгч, СХС-ийн 2018, 2019 оны ажлын тайланг хэлэлцэнэ. /сумын ИТХ-ын 2016-2020 онд баримтлах бодлогын 3.5-д/	жилийн хуралдаан аар	Зөвлөмж хүргүүлнэ		Сум хөгжүүлэх сангийн хэрэгжилтийг Тэргүүлэгчдийн хурлаар 1 удаа хэлэлцэн төлөгдөөгүй 8 зээлийн талаар эвлэрүүлэн зуучлагчид холбогдох албан тушаалтнаас өргөдөл гарган, 4 зээлдэгч төлбөрөө барагдуулан, хугацаа хэтэрсэн зээлээс 20,3 сая төгрөг төлөгдөж эргэн төлөлт 66.4 хувьтай байна.	1,3-р улиралд	100%

1.2.12	Амьжиргааг дэмжих зөвлөлийн ажлын тайланг хэлэлцэх /Нийгмийн халамжийн тухай хуулийн 27.1, 27.2, АДЗ-ийн дүрмийн 1.2-т/	Тэргүүлэгч дийн хурлаар 1 удаа	Зөвлөмж өгөх		Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулан, ажлын тайланг хэлэлцсэн, зөвлөлийн хурал 24 удаа хуралдаж, 23 асуудал шийдвэрлэсэн, өрхийн орлогыг дээшлүүлэх 2019 оны зорилтот өрхийн нэрсийг батлан, хамтран ажиллав.	4-р улиралд	100%
1.2.13	Суманд өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагаа хяналтыг сайжруулна /сумын ИТХ-ын 2016-2020 онд баримтлах бодлогын 3.3-т/	Тайланг хэлэлцэнэ	Зөвлөмж, тотоолын биелэлт 80 хувиас дээш		Өмч хамгаалах зөвлөл төлөвлөгөө гарган, хөрөнгө бэлтгэхээр саналаа ирүүлсэн 2 байгууллагын саналыг хэлэлцэн дүгнэлтийг хүргүүлэн ажиллалаа.	3-р улиралд	100%
1.2.14	Хог хаягдлын талаар мөрдөх журмыг Хууль зүйн яаманд явуулж, хянуулах батлуулах /сумын ИТХ-ын 2016-2020 онд баримтлах бодлогын 3.2-т/	Хувийн хэрэг бүрдүүлэн явуулах	Хэм хэмжээний актын бүртгэл ирнэ		2019 оны 06 дүгээр сарын 14 ны өдрийн ИТХ-ын хуралдаанаар Хог хаягдлын талаар мөрдөх журамд нэмэлт тодотгол оруулан хэлэлцэж, хувийн хэргийг бүрдүүлэн сумын ЗДТГ-аас хууль зүйн яаманд хүргүүлсэн. Захиргааны Ерөнхий хуулийн хүрээнд дахин судалж, хавсралтыг тус тусад нь батлан ирүүлэх талаар Хууль зүйн яамнаас дүгнэлт ирсэн.	2-р улиралд	70%
1.2.15	Иргэдийг төрийн дээд шагнал, одон медалиар шагнуулах тухай саналыг хэлэлцэн шийдвэрлэж уламжилна/ сумын ИТХ-ын 2016-2020 онд баримтлах бодлогын 4.7-д/	5 аас доошгүй иргэн	80 хувь нь шагнагдана		Монгол улсын Төрийн дээд шагнал, одон медалиар шагнуулах тухай 6 иргэний тодорхойлолтыг 2019 оны 03,04,12,13,16 дугаар тогтоолоор батлан холбогдох газруудад хүргүүлж, 3 иргэн шагнагдсан.	Тухай бүр	100 %
1.2.16	Аймгийн аварга малчинд тодорхойлогдож буй малчдын материалыг хэлэлцэнэ / сумын ИТХ-ын 2016-2020 онд баримтлах бодлогын 1.29-д/	Баг бүрээс 1 ээс доошгүй малчин шалгаруул ах	5 аас доошгүй тодорхойлолтыг хэлэлцэн уламжилна		Тодорхойлолтыг хэлэлцэн уламжилна, хугацаа хүлээгдэж буй	4-р улиралд	100%

1.2.17	Алдарт эхийн I, II зэргийн одонгоор шагнуулах болзол хангасан эхчүүдийн материалыг хэлэлцэж уламжилна./ Олон хүүхэд төрүүлэн өсгөсөн эхчүүдийг урамшуулах хуулийн хүрээнд/	Болзол хангасан эхчүүдийн тоогоор	Болзол хангасан эхчүүд шагнагдана бүгд		Алдарт эхийн I, II зэргийн одонгоор шагнуулах болзол хангасан эхчүүдийн материалыг хэлэлцэж Аймгийн ИТХ-д уламжлан, 2019 оны 06 дугаар сард 3 эх, 2 дугаар зэргийн одонгоор шагнагдсан.	1-р улиралд	100%
1.2.18	Хүүхдийн эрхийг хэрхэн хангаж ажиллаж байгаа талаар сумын Засаг даргын мэдээлэл сонсоно сумын ИТХ-ын 2016-2020 онд баримтлах бодлогын 1.23-д/	Тэргүүлэгч пийн хурлаар 1 удаа	Хүүхдийн эрхийг хангах хүрээнд хийх ажил үр дүнтэй хэрэгжинэ		2019 оны 11 дүгээр сарын 21 ны өдөр Хүүхдийн эрхийн талаар сумын Засаг даргын болон, сумын хүүхдийн төлөө зөвлөлийн мэдээлэл сонсож, улмаар үндэсний сургагч багшаас Хүний хөгжлийн талаар 4 цагийн илтгэл сонсов.	2,3-р улиралд	100%
1.2.19	Боловсролын байгууллагад хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн гүйцэтгэлийн тайланг хэлэлцэнэ. /сумын ИТХ-ын 2016-2020 онд баримтлах бодлогын 1.1-д/	1-2 удаа хэлэлцэж, Зөвлөмж гаргана	Төсөл хөтөлбөр 80 аас дээш хувиар биелнэ		Боловсролын байгууллагад хэрэгжиж буй сайн багш, 6 настай хүүхдийн гэр өргөө, англи хэлний үндэсний хөтөлбөрийн тайланг ирүүлсэн, гүйцэтгэл 80 хувийн хэрэгжилттэй байна.	3 улиралд	70%
1.2.20	Эрүүл мэндийн төвд хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн тайлан, мэдээлэл сонсоно/ сумын ИТХ-ын 2016-2020 онд баримтлах бодлогын 1.3-д/	1-2удаа хэлэлцэж, Зөвлөмж гаргана	Төсөл хөтөлбөр 80 аас дээш хувиар биелнэ		Эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж буй элэг бүтэн монгол, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх хянах, халдварт бус өвчинтэй тэмцэх, сайн эмч хөтөлбөрүүдийн биелэлтийг авч ажиллав.	2,3-р улиралд	70%
1.2.21	Аялал жуучлалын төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцэх сумын ИТХ-ын 2016-2020 онд баримтлах бодлогын 1.15 -д/	1удаа	Хэрэгжилт 60 хувьд хүргэнэ		Төлөвлөгөө гарган, холбогдох газруудад уламжлан ажиллаж байна. 8 дугаар хуралдаанаар хэлэлцэнэ.	2-р улиралд	70%
1.2.22	Орон нутгийн тусгай хэрэгцээнд болон орон нутгийн хамгаалалтанд		100 хувь хангаж ажиллана		ИТХ-ын хуралдаанаар орон нутгийн тусгай хамгаалалтанд авахаар 2 газрын, иргэдийн саналыг үндэслэн		

	авах газрын тоог нэмэгдүүлнэ// сумын ИТХ-ын 2016-2020 онд баримтлах бодлогын 1.4-д/	1 ээс доошгүй газар авна			тусгай хэрэгцээнд авахаар 2900 га газрыг 50, 51 дугаар тогтоолоор шийдвэрлэн, Аймгийн Засаг дарга, ашигт малтмалын газруудад хүргүүлж, улсын нөөцөд авсан газартай давхцалтай болох талаар хариу ирсэн.		70%
1.2.23	Иргэдээ соён гэгээрүүлэх талаар хөтөлбөр, төсөл, сургалт явуулахыг дэмжинэ / сумын ИТХ-ын 2016-2020 онд баримтлах бодлогын 1.18-д/	2 удаа сургалт явуулах	300 гаруй иргэнд хүрнэ		Сургуулийн 120 гаруй хүүхэд, 48 иргэн, 5 гэр бүлд “Аз жаргалтай гэр бүлийн” сургалт хийгдсэн, төлөөлөгч Ч.Эрдэнэцэцэг багийнхаа 112 өрхийн 200 гаруй иргэнд ОНХС–ийн талаар сургалт явуулсан.	3-р улиралд	100%
Хоёр Нутгийн өөрөө удирдах байгууллагыг бүх талаар хөгжүүлж, түүний ил тод нээлттэй байдлыг хангана							
2.1	Багийн ИНХ-ын даргын ажлын тайлан, үр дүнг тооцон хамтран ажиллана// сумын ИТХ-ын 2016-2020 онд баримтлах бодлогын 2.9-д/	Улирал бүр тайлан ирүүлнэ	20 тайлан авна, зөвлөмж 1 удаа хүргүүлнэ		5 багийн ИНХ-ын даргын ажлын тайланг хүлээн авч, бүртгэл хөтөлсөн, Дарга нарт 2 удаа мэдээлэл солилцох, ажлын байрны дагалдан сургалт явуулсан. Буга багийн ИНХ-ын дарга Ч.Эрдэнэцэцэг багийнхаа талаар 10 аад төрлийн судалгаа гаргасан, БИНХ-аас 12 тайлан ирүүлсэн.	4 улиралд	100%
2.2	Сумын ИТХ-аас 2020 онд хэрэгжүүлэх ажлаар иргэдийн саналыг авч ажлын төлөвлөгөөнд тусгана /Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль/	Санал авсан саналын хуудасны тоо	Иргэдийн оролцоо нэмэгдэнэ		ИТХ-аас 2020 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах ажлаар иргэдээс санал авсан.	1-4-р улиралд	100%
2.3	Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг бүртгэж, Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулан, холбогдох шийдвэрийг гаргуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.// сумын ИТХ-ын 2016-2020	Өргөдөл, гомдлын тоо	Ирсэн өргөдлийн 90 доошгүй хувийг шийдвэр лэнэ		Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд иргэдээс ирсэн 16 санал хүсэлтээс 11 ийг байгууллага өөрөө шийдвэрлэж, бусад байгууллагад 5 санал хүсэлтийг хүргүүлж ажиллав. Байгууллагад 23 өргөдөл, гомдол ирсэнийг бүртгэн 18 ийг хугацаанд нь барагдуулан, бусад байгууллагад 5 өргөдлийг шилжүүлсэн.	1-4-р улиралд	100%

	<i>онд баримтлах бодлогын 4.5-д/</i>						
2.4	Иргэний танхимаар хийгдэх ажлын төлөвлөгөө батлуулж, иргэний танхимын үйл ажиллагааг сайжруулна/ <i>сумын ИТХ-ын 2016-2020 онд баримтлах бодлогын 4.4-д/</i>	Иргэний танхимаар явагдсан үйл ажиллагааны тоо	Төлөвлөгөөний хэрэгжилт 80 аас дээш хувь		Буга багийн ИНХ-ын дарга иргэний танхимыг хариуцан ажиллаж Аймаг, сумын ИТХ, Тэргүүлэгчдээс гарч буй тогтоол шийдвэр, бусад хууль тогтоомжийг сурталчилан ажиллав. Иргэний танхимд 3 хэлэлцүүлэг, 8 хурал, 4 сургалт, Буурал, Буга багийн ИНХ-ын дэг батлах хэлэлцүүлэг зохион байгуулагдаж, 100 гаруй иргэн хамрагдлаа.	1-р улиралд	100%
2.5	Тэргүүлэгчдийн бүрэн эрхийн хэрэгжилтийг ханган ажиллахад дэмжлэг үзүүлнэ / <i>сумын ИТХ-ын 2016-2020 онд баримтлах бодлогын 2.6-д/</i>	1-2 удаа зөвлөмж хүргүүлнэ	Тэргүүлэгчдийн оролцоо 80 аас дээш хувь		Тэргүүлэгчдийн бүрэн эрхийг хэрэгжүүлэн ажиллахад бүх талаар дэмжиж, хуралдааны хэлэлцэх асуудлыг 1 ээс доошгүй хоногийн өмнө судалгаа, лавлагаа, тооцоолол, хуулийн заалтын хамт хүргүүлэн ажиллаж байна.	1-4-р улиралд	100%
2.6	Сумын ИТХ-ын төлөөлөгч, дарга нарийн бичгийн дарга, улс төрийн албан тушаалтнуудын 2018 оны Хөрөнгө орлогын мэдүүлгийг хугацаанд авч хүргүүлнэ./ <i>НАНБХАСЗА СЗУСТХ 24.1.4-м/</i>	Хөрөнгө орлогоо мэдүүлсэн хүний тоо 27	Цахимаар 80 аас дээш хувь нь гаргах		Авилгын эсрэг хуулийн мэдүүлэг гаргах хугацаа болох 02 дугаар сарын 01-15 ны дотор 27 мэдүүлэгчийн ХАСХОМ-ийг авч ажилласан, ХАСХОМ гаргах албан тушаалтануудыг нэрсийг гарган 01 сард АТГ-т хүргүүлсэн.	1 сард	100%
2.7	Сумын ИТХ-ын болон Тэргүүлэгчдийн хуралдааны материалыг, архивын стандарт, заавар журмын дагуу бүрдүүлнэ. / <i>Архивын тухай хууль/</i>	ХН-2 үүсгэнэ	100 хувь нэгж үүсгэнэ		ИТХ-ын байгууллагын 2018 оны байнга болон түр хадгалах баримт, Тэргүүлэгчдийн хуралдааны материал, ИТХ-ын хуралдааны материал, захирамжийг холбогдох хууль, журмын дагуу бүрэн бүрдүүлэн, хадгаламжийн нэгж үүсгэсэн. Улсын архивын үзлэг угтан ажлын төлөвлөгөө боловсруулан, үзлэгт нийт байгууллагууд сайн шалгагдаж, ИТХ нь 90 хувийн үнэлгээтэй дүгнэгдсэн.	1-4-р улиралд	100%

2.8	Мэдээ тайланг графикийн дагуу гаргаж Аймгийн ИТХ-ын ажлын албанд хүргүүлнэ./аймгийн ИТХ-ын даргын 16 тоот захирамж	Мэдээ,тайлангийн тоо	Мэдээ тайланг 90 ээс дээш хувиар явуулна		Мэдээ тайлангийн графикийг мөрдөн , тайлангийн хоцрогдол гаргаагүй. Графикт 17 мэдээг хүрүүлэв.	6,12 сард	100%
2.9	Хурал цахим сайтыг хөтөлж мэдээллийг тухай бүрд нь тавина /Мэдээллийн ил тод байдал, ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 14-м/	Мэдээний тоо	Хандалтын тоогоор		Сумын НӨУБ-ын үйл ажиллагааны талаарх мэдээлэл, цаг үеийн ажлыг цахим сангаар байнга сурталчлан, хөтөлж явуулснаар хандах иргэдийн тоо улам нэмэгдэж байна.	Тухай бүр	100%
2.10	“Хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр”ийг тэмдэглэнэ. /Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дүрмийн 21-м/	9 сард 1 удаа	Хамаарал бүхий иргэдийн 80 аас дээш хувийг хамруулна		Хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр-ийг тэмдэглэх тухай зөвлөмж аймгийн ИТХ-аас ирж, удирдамж гарган ИТХ-ын даргын зүгээс хэлмэгдэгсдийн үр хүүхдүүдэд хүндэтгэл үзүүлэв.	9 сард	100%
2.11	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулна. /сумын ИТХ-ын 2016-2020 онд баримтлах бодлогын 1.26-д/	300 гаас дээш иргэн	90 ээс дээш хувь		Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулан 80 гаруй иргэн оролцсон.	2,3 улиралд	70%
2.12	Улаан загалмайн хорооны ажлыг эрчимжүүлж, цаг үеийн тулгамдсан асуудлыг тухай бүрд нь шийдвэрлэнэ// сумын ИТХ-ын 2016-2020 онд баримтлах бодлогын 1.28-д/	Хандивын хэмжээ 200.000 д хүргэнэ	5 багийн малчид, иргэдийн 80 аас дээш хувь хамрагдана		Хорооны ажлыг эрчимжүүлэн, төлөвлөгөөтэй ажиллаж, багийн өрхүүдээр 2-3 удаа сурталчилгаа хийж, 60 гаруй иргэн хамрагдлаа. 4 багийн 4 малчин 600.000 төгрөгийн мөнгөн хандив, 2019 оны татварт иргэдээс 120,000 төгрөг орууллаа.	Улирал бүр	100%
2.13	Ирсэн, явсан бичиг баримтыг цаг тухай бүрд нь бүртгэж, танилцуулан, хэрэгжилтийг ханган ажиллана /Архивын тухай хуулийн 20.4-м/	Харилцсан бичгийн тоо	Эргэлтийн тайланг гаргана		Ирсэн, явсан бичиг баримтыг цаг тухай бүрд нь бүртгэж, танилцуулан, бүртгэлийн картаар хяналт тавьж, биелэлт тооцон, эргэлтийн тайлан гарган ажиллаж байна	Тухай бүр	100%

2.14	Архив албан хэрэг хөтлөлтийг стандартын дагуу хөтлөн, аймгийн архивын тасагт ХН үүсгэн хүлээлгэн өгнө	20 оос доошгүй баримт	100 хувь хүлээлгэн өгнө		ИТХ-ын байгууллагын 2000-2008, 2009-2013 оны байнга болон түр хадгалах 37 хадгаламжийн нэгжийг холбогдох хууль, журмын дагуу үдэж хавтаслан, байнга хадгалах болон захирамжлалын хадгаламжийн нэгжийг скайнердаж, PDF файл руу хувиргаж цахим программд оруулан , Аймгийн архивын тасагт актаар хүлээлгэн өгөв.	1,2-р улиралд	100%
Зорилт-3. Хурлын хяналтын тогтолцоог боловсронгуй болгож,үр нөлөөг дээшлүүлнэ							
3.1	Төсөвт байгууллагуудын өөрийн орлого бүрдүүлэлтэнд хяналт тавина /төсвийн тухай хууль/	Тэргүүлэгч дийн хурлаар 1 удаа хэлэлцэнэ, 2 удаа хяналтын ажил хийгдэнэ	80 аас дээш хувьд		ИТХ-аас хяналтын ажлын хэсэг байгуулан орон нутгийн хөгжлийн сан, төсвийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэл, шилэн дансны мэдээлэлд хяналт тавих удирдамж, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.	6,11 сард	70%
3.2	Төсөвт байгууллагуудын төсвийн зарцуулалтанд хяналт тавина /сумын ИТХ-ын 2016-2020 онд баримтлах бодлогын 3.7-д/	Хяналтыг 2 удаа хийнэ	Зөвлөмж хүргүүлнэ		ИТХ-аас хяналтын ажлын хэсэг байгуулан орон нутгийн хөгжлийн сан, төсвийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэл, шилэн дансны мэдээлэлд хяналт тавих удирдамж, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.	6,11 сард	70%
3.3	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлын орц, явц, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж хяналтын зөвлөл, ажлын хэсгийн ажлыг эрчимжүүлнэ. /сумын ИТХ-ын 2016-2020 онд баримтлах бодлогын 3.8-д/	Төсөл хөтөлбөр тус бүр дээр 2 удаа ажил явуулна	Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэн 1 удаа зөвлөмж гаргах		ИТХ-аас хяналтын ажлын хэсэг байгуулан орон нутгийн хөгжлийн сан, төсвийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэл, шилэн дансны мэдээлэлд хяналт тавих удирдамж, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.	3,4 улиралд	70%

3.4	Уул уурхайн олборлолт, хууль бус ашигт малтмалын үйл ажиллагаа, эвдэгдсэн газрын нөхөн сэргээлтийн ажилд хяналт тавьсан тайланг сонсоно /сумын ИТХ-ын 2016-2020 онд баримтлах бодлогын 3.6 -д/	Төлөөлөгч ид 1 удаа хяналт хийнэ	Тайланг 2 удаа сонссон байна		Хууль бус ашигт малтмал эрэгчдийн үйл ажиллагаагаар эвдэгдсэн Таван толгойн Хар хуруу орчмын газрын хэмжээг 0.3 га- р тогтоон нөхөн сэргээлтийн ажилд албан тушаалтнаас 2 удаа хяналт тавьсан бөгөөд холбогдох газруудад мэдээлж ажилласан.	2,3 улиралд	70%
3.5	Төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт, зарцуулалтанд хяналт тавьж ажиллана/ сумын ИТХ-ын 2016-2020 онд баримтлах бодлогын 1.12,3.5-д/	Төлөөлөгч ид 1 удаа хяналт хийнэ	Тайланг 2 удаа сонссон байна.		ОНХС, төсөл хөтөлбөр, Монгол улсын Засгийн газрын 153 дугаар тогтоолын хэрэгжилтэнд ИТХ-ын төлөөлөгч Б.Чинбаатар, Б.Энхтүвшин, Г.Батцэнгэл, Ч.Эрдэнэцэцэг, иргэний төлөөлөл И.Шинэбаяр, Б.Батхуяг, В.Очирдорж, ажлын албаны дарга П.Амгалан нараас 2019 оны 04-р сарын 07 ноос 10 ны хооронд суманд баригдсан 100 хүүхдийн цэцэрлэг, ОНХС ийн хөрөнгөөр хийгдсэн соёлын төвийн их засварын ажилтай танилцаж, зөвлөмж хүргүүлэн ажиллав.	2,3 улиралд	100%
3.6	Үдийн цай хөтөлбөрт хяналт тавина сумын ИТХ-ын 2016-2020 онд баримтлах бодлогын 3.11-д/	2 удаа хяналт тавина	Төлөөлөгчдийн 50 иас доошгүй хувь оролцоно		Байгууллагын үйл ажиллагаатай танилцахад сургууль дээр 1 удаа үдийн цайтай танилцсан.	Улирал бүр	40%
3.7	Эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагаанд хяналт тавина. /сумын ИТХ-ын 2016-2020 онд баримтлах бодлогын 3.12-д/	1 удаа хяналт тавина	Төлөөлөгчдийн 50 иас доошгүй хувь оролцоно		Танилцаагүй	2,4 улиралд	0
3.8	Сумын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавина/ сумын ИТХ-ын 2016-2020 онд	12 сард хяналт тавина	Хэрэгжилт 80 аас дээш хувьд хүргэнэ		Сумын Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийн явцыг 06 дугаар сард хэлэлцэж зөвлөмж	2,4 улиралд	100%

	<i>баримтлах бодлогын 3.4.-д/</i>				хүргүүлэв. 8-дугаар хурлаар хэлэлцэнэ.		
3.9	Сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэнд хяналт тавина/ <i>сумын ИТХ-ын 2016-2020 онд баримтлах бодлогын 3.12-д/</i>	2 удаа	Хэрэгжилт 80 аас дээш хувьд хүргэнэ		2019 оны 12 дугаар сарын 18 ны өдөр 2019 оны үндсэн чиглэлийн хэрэгжилтэнд хяналт үнэлгээ хийсэн. Хэрэгжилтийн талаар зөвлөмж өгсөн.	2,4-р улирал	70%
3.10	Авилгын эсрэг, авилгаас ангид аймаг дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллана / <i>АТХ,НАНБХАСЗУСТХ/</i>	1 удаа	Хэрэгжилт 80 аас дээш хувь		Дэд хөтөлбөрийн хүрээнд “Батламж, зөвлөмж” арга хэмжээнд 94 ТАХ хамрагдсан, Соёлын төвийн хөгжмийн багштай хамтран 2 байгууллага дээр Авилгын эсрэг хуулийн сургалт хийгдсэн, 12 сард төлөвлөгдсөн сургалт хийгдэнэ.	2,3 улиралд	100%
3.11	Эрх зүйн боловсрол-Эрс өөрчлөлт дэд хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавина. / <i>Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр,Нийтийн сонсголын тухай хууль/</i>	Тайланг 1 удаа хэлэлцэнэ	Хэрэгжилт 80 аас дээш хувь		Дэд хөтөлбөрийн хүрээнд Төрийн албан хаагчдаас албан тушаалын чиг үүрэгтэй холбоотой мэдээлэлийг иргэдэд хүргэн ажиллаж байгаа ба хөтөлбөрийн хэрэгжилтийг холбогдох албан тушаалтанаар гаргуулан АИТХ-д хүргүүлсэн.	3,4 улиралд	100%
3.12	Төсөвт байгууллагуудын төрийн албан хаагчдын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих ажлыг Засаг даргад хүргүүлнэ / <i>Хөдөлмөрийн болонТАТхууль/</i>	Тайланг 1 удаа сонсоно	Тайланг авна		Хүргүүлээгүй	4 улиралд	0
3.13	Иргэдийн санал, хүсэлтийн дагуу хяналтын ажил зохион байгуулна. / <i>сумын ИТХ-ын 2016-2020 онд баримтлах бодлогын 3.3-д/</i>	Жилд 1 удаа зохион явуулна	Тайлан		Сумын ИТХ-аас хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх талаар 3 иргэнээс БИНХ-ын хэлэлцүүлэгийн үеэр санал гарсан, төлөвлөгөө удирдамж боловсруулан ажиллаж байна.	Тухай бүр	70%

Дөрөв.ИТХ-ын төлөөлөгч нь тойргийнхоо ард иргэдтэй байнгын харилцан ажиллагаатай байж, тэдний эрх ашгийг төлөөлөн хэрэгжүүлнэ							
4.1	“Төлөөлөгчийн нэг өдөр” үйл ажиллагааг уламжлал болгон зохион байгуулж, иргэдэд хууль тогтоомж, Төр засгийн бодлого, ИТХ-ын шийдвэрийг сурталчилж, иргэдтэйгээ хамтран ажиллана. / сумын ИТХ-ын 2016-2020 онд баримтлах бодлогын 4.1-д/	Жилд 1 удаа	Багт хүрсэн байна		Төлөөлөгчдийн нэг өдөр арга хэмжээг багуудад зохион явуулахаар удирдамж төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.	3-р улиралд	100%
4.2	Сумын өрхийн 50%-д угийн бичиг хөтлүүлэх ажлыг эрчимжүүлнэ/ сумын ИТХ-ын 2016-2020 онд баримтлах бодлогын 1.10-д/	Өрхийн 50 хувь	Угийн бичиг хөтлөсөн өрхийн тоо		Сумын номын сангаас Угийн бичиг хөтлөх талаар сургалт явуулж сургалтанд хамрагдсан 28 иргэнээс судалгаа авахад 60 гаруй хувь нь хөтөлдөг байна, эрчимжүүлэх шаардлагатай.	1-р улирлаас	70%
4.3	ИТХ, ЗДТГ-ын мэдээллийг багт хүргэж ажиллана/ сумын ИТХ-ын 2016-2020 онд баримтлах бодлогын 2.11-д/	Багийн ИНХ бүрээр	10 аас доошгүй удаа		Багуудын иргэдийн нийтийн хурлын үеэр 5 багийн 380 гаруй иргэнд мэдээлэл хүргэн ажилласан.	Улирал бүр	100%
4.4	Албан байгууллагуудын ажилтай танилцаж тэнд ажиллагсадын санал бодлыг сонсох /сумын ИТХ-ын 2016-2020 онд баримтлах бодлогын 4.5-д/	2 удаа	12 удаа		Сургууль, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, өвөлжилтийн бэлтгэл ажилтай танилцаж, Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэн, 7 дугаар хуралдааны санал шүүмжлэлийн дагуу, төсвийн гүйцэтгэлийн талаар байгууллагуудад тэмдэглэлээр зөвлөмж хүргүүлсэн.	2,3 улиралд	100%
4.5	Төлөөлөгчдөд хурлын байгууллагаас хийсэн ажлын тайланг хүргэнэ. / МУ-ын мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 14/	Жилд 1 удаа	90 ээс дээш хувь		Тайланг хүснэгтээр гарган хүргүүлэв	4-р улиралд	100%
4.6	Хүүхдийг цахим ертөнцөөс ангид байлгах зорилгоор Номын санг тогтмол ажиллуулах бодлого барьж ажиллана. /сумын ИТХ-ын	Хүүхдийн 30 аас доошгүй хувь	80 хувиас дээш		Хүүхдийг цахим ертөнцөөс ангид байлгах, номонд дуртай болгох талаар соёлын төвийн номын санчтай хамтран Дэлхийн номын түүхүүд цуврал илтгэлийг 4 ангийн 118 хүүхдэд хүргэн, ном унших	Жилдээ	

	2016-2020 онд баримтлах бодлогын 1.2-д/				хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 40 гаруй хувиар нэмэгдсэн байна.		100%
Тав. ИТХ-ын тэргүүлэгчид, ажлын албанаас зохион байгуулах үйл ажиллагааны талаар							
5.1	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг тусгай төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, хийсэн ажлынхаа тайланг аймгийн ИТХ-ын ажлын албанд хүргүүлнэ. сумын ИТХ-ын 2016-2020 онд баримтлах бодлогын 1.26-д/	Улиралд 1 удаа	4 удаа		Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл нь 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажллаж байна.	Улирал бүр	70%
5.2	Аймгийн Улаан загалмайн хороотой хамтран ажиллаж цаг үеийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэж тайланг хүргэнэ / сумын ИТХ-ын 2016-2020 онд баримтлах бодлогын 1.28-д/	Улиралд 1 удаа	4 удаа		5 багийн өрхөөр орж хорооны ажлаа сурталчилсан төдийгүй 5 дугаар сарын 8 буюу “Хүмүүнлэгийн өдөр”-өөр гишүүд дэмжигчдийн эгнээг өргөтгөх ажил зохион байгуулж, 140 гаруй малчинд сурталчилгаа явуулж, татварт 120 гаруй мянган төгрөгийг орууллаа.	Улирал бүр	100%
5.3	“Хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр”-ийг тэмдэглэх ажлын төлөвлөгөө гарган, хэрэгжүүлж ажлын тайлангаа аймгийн ИТХ-ын ажлын албанд хүргүүлнэ./МУ-ын ЦАУЗБУК-ын дүрмийн21-т/	1 удаа	9 сард 100 хувь		Хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр”-өөр төлөвлөгөө гарган , нөхөн олговрын хуулийн хамааралд хамаарах 2 иргэний өргөдөлийг хүлээн авч, хэрэгжүүлсэн ажлын тайланг хүргүүлэв.	9 сард	100%
5.4	Ахмадын хорооны үйл ажиллагааг дэмжиж, мэдээллээр ханган хамтарч ажиллана. /сумын ИТХ-ын 2016-2020 онд баримтлах бодлогын 1.5-д/	2 удаа	100 хувь		Ахмадын хороотой хамтран ажиллаж, “Олон улсын ахмадын өдөр”-өөр ахмадуудын дунд явуулах тэмцээнийг зохион байгуулахад хамтран оролцлоо. Ахмадын төлөөлөлөөс ирсэн хүсэлтийг хүлээн авч барагдуулав.	Тухай бүр	100%
5.5	Төрийн болон төрийн бус байгууллага, ОУ-ын төсөл хөтөлбөрүү дийн үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллаж ажлын байр нэмэгдүүлэх,	Сургалтанд 2 удаа оролцож, 100 аас	Хэрэгжилтээр		Эдийн засгийн тусгай төслийн хүрээнд оёдлын 2 бүлэг 14.1 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн төсөлд хамрагдлаа. Тус төслийн хүрээнд, суманд ажлын хэсэг томилогдон,	1 улирлаас	

	шаардлагатай хөрөнгийг төсөвт суулгах талаар санаачлагатай ажиллана. <i>сумын ИТХ-ын 2016-2020 онд баримтлах бодлогын 1.12-д/</i>	доошгүй иргэнд хүргэнэ			иргэдэд 3 удаа, аймагт 3 удаа чадавхжуулах сургалтанд хамрагдаж, оёдолын 2 бүлэгт байнгын ажлын байр 4 ажиллаж байна.		100%
5.6	Орон нутгийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид, баялаг бүтээгчдийг дэмжих санал хүсэлтийг хүлээн авч хэрэгжүүлнэ. <i>/сумын ИТХ-ын 2016-2020 онд баримтлах бодлогын 2.7-д/</i>	Тэргүүлэгчдийн хурлаар 2 удаа	Ажлын үр дүн, тайлан		“Дэлхийн зөн Франц” олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй эдийн засгийн тусгай төслийн хүрээнд оёдлын үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч бүлэг 14.1 сая төгрөгийн төсөлд хамрагдлаа.	жилдээ	100%

ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧИД